



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-13

1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2025.07.03-ны өдөр мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	5-6
2.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл	6-11
3.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	11-13

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 07 дугаар сарын 09-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 30 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Ганбаатар, Б.Мөнхсоёл, Б.Үүрийнтуяа;
Чөлөөтэй: Т.Аубакир, Д.Батбаяр, Ц.Даваасүрэн, Б.Түвшин, Д.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Н.Алтанхуяг, З.Мэндсайхан.

Нэг.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /2025.07.03-ны өдөр мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, А.Энхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал Э.Түвшинжаргал, Санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл, хөтөлбөрийн зохицуулагч Л.Хосбаяр, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, Р.Батболд, Б.Жаргалан, Д.Цогтбаатар нарын тавьсан асуултад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Х.Ганхуяг: “Засгийн газрын өрийн баталгаа гаргах, зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд оруулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15

Татгалзсан: 2

Бүгд: 17

88.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Ч.Номин нарыг оруулж байгаа талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулга үг хэлэв.

Х.Ганхуяг: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Ч.Номин нарыг нэмж оруулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 2
Бүгд: 18
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Номин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 31 минут үргэлжилж, 29 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 65.5 хувийн ирцтэйгээр 11 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 10 цаг 30 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Байнгын хорооны гишүүдийн олонх ирсэн тул Төсвийн байнгын хорооны 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя аа. Жамбын Батсуурь, Пүрэвбаатарын Мөнхтулга, Даваахүүгийн Пүрэвдаваа, Даваагийн Цогтбаатар, Пүрэвжавын Сайнзориг, Ринчендоржийн Батболд, Жадамбын Баясгалан, Жуковын Алдаржавхлан, Хөххүүгийн Болормаа, Батжаргалын Заяабал, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Чинбатын Номин, Гомбын Ганбаатар, Жигжидийн Батжаргал. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2025 оны 7 сарын 3-ны өдөр мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг.

2.“Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл анхны хэлэлцүүлэг.

3.Монгол Улсын Их Хурлын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор санал гаргах гишүүн байгаа юу?

Саналгүй байна хэлэлцэх асуудалдаа оръё. **Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.**

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга.

Нэгдсэн хуралдаан анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбарыг та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна айн асуулт асуух гишүүн байхгүй байна гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан танилцуулна. Өнөөдөр байхгүй юм уу? Хэн танилцуулах юм Баясгалан гишүүн танилцуулна.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

10.33 цаг

Хоёр дахь асуудалдаа орёе.

Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье ээ.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хишгээгийн Нямбаатар НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Луулайн Хосбаяр Нийслэлийн санхүү, эдийн засаг, хөгжлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх төсөл хөтөлбөрийн зохицуулагч.

Ажлын хэсгээ оруулаарай. Маамын Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Эрдэнийн Түвшинжаргал Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга.

Ажлын хэсэг яасан бэ?

Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Батболд гишүүнээр тасалъя аа.

Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд.

Энэ хэлэлцэж байгаа асуудал өчигдөр Төсвийн байнгын хороогоор орсон юм л даа. Уг нь би дэмжсэн юм. Тэгээд сүүлд нь судалж байсан. Энэ чинь хөөе 900 гаран сая доллар, 928 билүү. 900 гаран сая доллар хорин дөрөвхөн километр зам юм байна лээ шүү дээ. Манай хажууд сууж байсан гишүүн Ботт бюлд оперэйшн дээрээс нь транспер нөхцөлөө нэмэх нь бас санхүүгийн финанс гээд тэгээд материал оройтож ирсэн өчигдөр бас бүрэн танилцаагүй байсан. Өчигдөр орой судалсан энэ чинь хөөе бараг тэрбум шахуу доллароор 24км зам барих юм билээ.

Тийм учраас энэ юун дээр болгоомжтой хандах ёстой шүү гэдгийг бас төсвийн гишүүддээ хэлье.

Энэ материалаа яг урьдчилж иймэрхүү тэрбум орчим долларын зээлийн эрх өгөх гэж байж Их Хурлын гишүүдэд урьдчилж материалаа 1, 2 хоногийн өмнө өгөх ёстой. Ийм яаралтай горимоор оруулж ирээд сайн судлаагүй байхад нь наадмын өмнө иймэрхүү юм хийж болохгүй гэж бодож байна судлах ёстой шүү гишүүд ээ.

Х.Ганхуяг: Үг хэлчихлээ. Батболд гишүүн.

Р.Батболд: Өдрийн мэнд хүргэе. Энэ саяын Ганбаатар гишүүний саналтай ер нь адилхан байгаад байгаа юм аа. Нийслэлийн замыг мэдээж өргөтгөөд барих нь тодорхой. Тэгээд тэрэн дээр зээл авах нь ойлгомжтой л доо. Бид нар өөрсдөө угаасаа барьж чадахгүйгээс хойш. Тэгэхдээ энэ нийслэлийн хийгээд байгаа ажлуудын энэ өртөг зардлыг ер нь яаж тооцоод байгаа юм бэ гэдэг асуудал ерөөсөө аягүй их ийм чухал сонин асуудал болоод байгаа юм. Зүгээр хувийн хэвшлийн хийж байгаа өртгөөс өндөр өртөгтэй юмыг бид нар дандаа зээлээр ингээд хийгээд байгаа юм. Уул нь бол дэмжээд байгаа юм. Тэгээд энэ өртгөө ер нь яаж тооцоод байгаа юм бэ гэдэг дээр л ерөөсөө ямар ч хариулт авч чадахгүй байгаа юм. Арай л дэндүү үнэтэй л замууд босоод байх шиг байх юм энэ чинь. 20, 30 сая доллароор 1 км замыг барихаар тооцоонууд яваад байдаг.

Энийг ер нь яаж үзээд байгаа юм. Энэ аудитын газар энэ тэр нь гол нь аудитын газрын дарга нэг урьдчилсан аудит энэ тэр хийдэг байя гэж яриад байгаа юм. Тэгэхээр энэ тэрийг нь оруулаад аудитыг нь хийлгээд яг өртөг зардал нь ямар байх юм энэ 9 зуугаад сая доллар чинь яг ингээд болоод байгаа юм уу, болохгүй байгаа юм уу гэдэг дүгнэлт энэ тэрийг нь авч байж явуулж байвал яасан юм бэ гэдэг ийм саналтай байгаа юм.

Тэгэхээр энэн дээр бас нэг яг километр нь хэдээр гараад байгаа юм. Яаж хийгдээд байгаа юм гэдэг дээр нэг нийслэл өөрөө бас нэг хариулт өгөөч.

Х.Ганхуяг: Хэн хариулах вэ? 6 номер.

Х.Нямбаатар: Энэ Батболд гишүүний ярьж байгаа шиг бид үнэ ханшаа тогтоодог зүйл биш л дээ. Энэ олон улсын нээлттэй тендерээр энэ олон улсын банкны шаардлага хангасан ТЭЗҮ боловсруулах компани шалгараад энэ дээр дэлхийн номер нэг компани Чайна констракшн шалгарч өөрөө банк эйбл ТЭЗҮ боловсруулж тухайн энэ төслийн өртгийг тодорхойлж үүнийг нь манай Зам тээврийн хөгжлийн төв ЗТЯ-ны дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөл, Үндэсний аудитын байгууллага, Сангийн яам бүгд дүгнэлт гаргаж оруулж ирж байгаа юм.

Зүгээр би Батболд гишүүн сүүлийн чуулганы нэлээн хэдэн хуралдаан дээр яг ийм асуудлууд хөндөөд байх шиг байна. Тэгээд би энэ дээр дахиад нэг хариулт хэлье.

Би таныг аливаа асуудалд ийм субъектив байдлаар битгий хандаасай гэж хэлэх гэсэн юм. Энэ өөрөө дэлхий бид энэ мөнгийг санхүүжүүлэхгүй. Энэ төсөв өөрөө дэлхийн зах зээлийн жишигт нийцэж үү үгүй юж гэдгийг санхүүжүүлэгч байгууллагууд Азийн дэд бүтцийн банк, Европын сэргээн босголтын банк, Эй Ти Би

гээд энэ байгууллагууд өөрөө энэ дээр давхар хяналт шалгалт хийж байж тухайн тендерт шалгарсан ААН-д тэр хэсэгт нь зээл олгох уу үгүй юу гэдгээ шийднэ.

Энэ санаанаасаа гаргаж ирж тавьдаг тоо биш.

Х.Ганхуяг: Тодруулах юм уу?

Р.Батболд: Энэ яалт ч үгүй нэг тийм Нямбаатар дарга аа би хэлээд байгаа шүү. Бодлогыг чинь дэмжээд байгаа. Тэгэхдээ наад нэг төсөвт өртөг янз бүрийн асуудал дээр чинь ерөөсөө дэмжмээргүй юмнууд яваад байгаа. Би хэлээд байгаа шүү дээ. Хувийн ААН-ийн ингээд бариад болоод байгаа юмыг та нар тэрнээс нь бараг энэ нугалсан үнээр шахуу юм хийлгэх гээд юм уу, эс үгүй бол 1.5 дахин үржүүлсэнтэй адилхан тийм өртөг гарч ирээд байгаа юм аа.

Тэгэхээр энийгээ яаж тооцоод байгаа юм бэ л гэж асуугаад байгаа юм. Тэгээд яах вэ гаднын зах зээлийн тэр мундаг байгууллагууд нь хийдэг л байх л даа. Тэд нар нь ямар ч учиртай тийм юм. Одоо бодвол тэр доллароо гарахаар тэгдэг юм уу яадаг юм уу, яадаг юм мэдэхгүй байна. Зүгээр ер нь бол тэгээд хэрэгжүүлэх гэж байгаа наад компанийг чинь дэлхийд номер нэг гэдгийг нь бас хэн ингээд тогтоогоод гаргаж ирчхээд байгаа юм. Тэгээд бид нар санхүүжүүлэхгүй гэж яриад байх юм. Энэ чинь зээл биз дээ. Бид нар зээл тавьж өр үүсгээд байна шүү дээ. Энэ өрөө бид нар л төлнө шүү дээ.

Х.Ганхуяг: Нямбаатар дарга.

Х.Нямбаатар: Би уг нь чуулганы хуралдаан дээр түрүүн тайлбарласан. Энэ бид ТЭЗҮ-ээрээ ЕРС нэмэх нь санхүүжилтээ гаргах нөхцөлтэйгөөр тендер зарлаад баригдаж дууссаны дараа тооллоороо эргэн төлөлтөө хийх энэ төсөл бүтэлгүйтсэн тохиолдолд 15 жилийн дараа Засгийн газар баталгааны дагаа дагуу үүрэг хүлээх л ийм л нөхцөлтэй зүйл.

Хоёрдугаарт Батболд гишүүнд хэлэхэд манайд энэ ерөөсөө огт ийм 1 дүгээр зэрэглэлийн авто зам баригдаагүй. Хувийн аль ч ААН хэвшил ийм зам ерөөсөө бариагүй ээ. Та интернэт рүү ороод БНХАУ-ын дэд бүтцийн бүх компаниудын эрэмбийг эрэмбэлсэн ранкийг хараарай. Тэрэн дээр Чайна Стэйт констракшн гээд компани 1 дүгээрт эрэмбэлэгдсэн байгаа. Энэ компани манай тендерт шалгарч байгаль орчны нарийвчилсан үнэлгээний хамт энэ ТЭЗҮ-ийг боловсруулсан.

Х.Ганхуяг: Жаргалан гишүүн нэмье. Тодруулга асууя.

Б.Жаргалан: Энэ Улсын Их Хурал дээр ялангуяа баяр наадмын үед хүмүүсийн анхаарал халамж суларсан байх үед нөгөө чоно борооноор гэдэг шиг маш их анхаарал сонор сэрэмжтэй байхгүй бол яаралтай горимоор ийм янз бүрийн асуудлууд орж ирж батлагддаг. Бүр ийм жишиг тогтжээ. Тэгээд уг нь энэ манай энэ 126 гишүүнтэй шинэ парламент аль болох асуудлыг ул суурьтай, тооцоо судалгаатай, хэлэлцүүлэгтэй, олон нийтийн оролцоотой шийддэг байх гэсэн зорилт тавиад байгаа.

Гэтэл өнөөдрийн энэ орж ирж байгаа асуудал ялгаа байхгүй яг л тийм аргаар явж байна. Өнөөдөр ерөөсөө бүх хэлэлцүүлгүүдээ хийгээд тэгээд баяр наадмын өмнө ингээд батлах гээд ямар асуудал орж ирж байна вэ гэсэн чинь нийт 918.6 сая

ам.долларын төсөвт өртөгтэй 1 дүгээр тойрог зам гэдэг зүйл дээр Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах гээд ингээд гэнэт ингээд баяр наадмын өмнө ороод ирж байгаа.

Өчигдөр бол миний ойлгосноор Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэх эсэх асуудал уначхаад дахиж санал хураасан гэж харагдаад байгаа юм. Тэгэхээр бид нар ингэж горимоо эвдээд, дэгээ эвдээд, хамгийн гол нь олон нийтийн оролцоо байхгүй мэдээлэл байхгүй ийм байдлаар Их Хурал ийм аймаар том дүнтэй асуудлуудыг шийдэж болохгүй. Тэгээд ийм зарчмаа бас барихыг бол энэ нийт гишүүдээсээ хүсэж байна аа.

Тэгээд энэ 918.6 сая ам.доллар гэдэг чинь маш их мөнгө шүү дээ. Тэгээд энэ бүх зүйл дээр Нямбаатар дарга та бол урьд хожид байгаагүй өндөр их дүнтэй төсөв захиран зарцуулж байгаа. Анх удаа бонд гаргаад тэрийгээ ингээд бас зараад явж байгаа хамгийн их мөнгөөр туйлж байгаа Хотын дарга. Магадгүй таны дараа томилогдох хотын дарга нар ингэж чадахгүй. Та энэ маш олон зүйл дээр жишиг болно. Тэгээд хотын асуудлыг байна шүү дээ хараа зөвхөн мөнгөөр шийддэггүй байхгүй юу. Хотын асуудал гэдэг бол ийм зохион байгуулалтын асуудал.

Хотын соёлын асуудал. Тэгээд маш их өндөр дүнтэй ерөөсөө их наядаас буухаа байчихсан төслүүд нь Туулын хурдны зам гэхэд 2.4 их наядын тендер зарлаад бас нэг Хятад компани бодвол бас л дэлхийн номер нэг байлгүй зарлачихсан явж байгаа. Шинэ Сэлбэ дэд төв дээр одоо юу болж байгааг бүгдээрээ мэдэж байгаа. Одоо энэ 1 дүгээр тойрог зам гээд 1 км зам нь 37 сая долларын өртөгтэй ийм зам барина гээд ороод ирлээ шүү дээ. Хотын асуудлыг мөнгөөр шийдэхгүй шүү. Тэгээд дандаа мөнгө ярьж орж ирнэ. Дандаа баахан ийм өндөр төсөвтэй тендерүүд зарлаж орж ирнэ. Дандаа Хятад компаниудыг янз бүрийн байдлаар магтана.

Тэгээд хотын асуудлыг бид нар бүгдээрээ шийдмээр байгаа. Энэ утаа түгжрэлээс бид нар бүгдээрээ ангижирмаар байгаа. Гэтэл ерөөсөө л ер ийм өндөр дүнтэй ийм төслүүд хэрэгжүүлэхгүй бол болохгүй гэсэн байдлаар л ингэж оруулж ирээд байгааг би үнэхээр ойлгохгүй байна. Тэгээд гишүүддээ уриалмаар байна. Ийм байдлаар бид нар асуудлыг ерөөсөө шийдэхгүй ээ.

Энэ тэрбум доллар чинь ийм бага мөнгө болчихсон юм уу? Ерөөсөө зүгээр л ингээд л нэг.

Х.Ганхуяг: Үг хэлчихсэн үү? Цогтбаатар гишүүн.

Да.Цогтбаатар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Өчигдөр асуудал хэлэлцэж байхад би Улсын Их Хурлын чуулган дээр нээлттэй хэлэлцэх юм байна гэж бодоод чуулган дээр зарим асуултаа асууя гэсэн түрүүн бас амжсангүй ээ.

Тэгээд түрүүн би бас асууж байгаад дутуу орхигдчихсон. Одоо энэ богино хугацаа байгаа, юм хийе гэж байгааг ойлгож байгаа. Гэхдээ төслийн бэлэн байдал хэр хангагдсан гэж үзэж байгаа вэ? Нийслэлд. Одоо жишээлэхэд энэ Үндэсний аудитын 2024 оны Засгийн газрын санхүүгийн тайланд хийсэн дүгнэлт дээр бол хөрөнгө босгосон төсөл бэлэн байдал хангаагүй гээд 5.7 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн 2024 онд. Одоо энэ чинь тэрбум орчим долларын төсөл. Дахиад бид нар жилийн дараа бэлэн байдлаа хангаж чадаагүй авсан зээлдээ ийм хэмжээний хүү

төлчихлөө гээд дахиад нэг ийм алдагдлын мөнгөн дүнг яриад сууж байх вий. Энэ дээр таны байр суурийг нэг тодруулах гэсэн юм.

Тэгээд 2 дугаарт нь энэ Занданшатар Ерөнхий сайд ийм алдаатай бичиг хийгээд сууж байна гэж би бодохгүй байна.

Түрүүн Нямбаатар дарга өөрөө чуулган дээр хариулахдаа надад хэлсэн. Эрдэнэс Монгол гэдэг компаниас зээлээ авч байгаа гэж ярьсан. Бид нарт тараагдчихсан байгаа танилцуулга өчигдөр Байнгын хороон дээр л анх удаагаа орж ирж байгаа юм. Яг энэ цаг нь тулаад ерөөсөө хурал дээр ийм зузаан материалтай шууд танилцаад л саналаа өг гэдэг байдлаар. Тэгээд энэнтэй нэг халти мулт танилцахаар ЭТТ компаниар 15 хувийнхаа санхүүжилтийг хийлгэнэ гээд байгаа байхгүй юу. Улсын Их Хурлын дарга Амарбаясгалан дарга бол жишээлэхэд алдаатай байгаа бол энийгээ зас гээд энэ төсөл санаачлагчид нь буцаагаад байсан. Одоо тэгээд Их Хурал ийм хариуцлагагүй байдлыг юу гэдэг юм. Нэг компани бүхэл бүтэн 2 компанийг хооронд нь андуураад яваад байхад энийг хэлэлцээд сууна гэх юм бол энэ чинь дэгээ зөрчихдөг юм уу? Улсын Их Хурлыг худлаа мэдээллээр хангасан болдог юм уу? Нэг ийм асуудал болох гээд байх шиг байна.

Гуравдугаарт нь энэ аудитын санал дээр бол танайх энэ нөгөө нэг төслийг дүгнэсэн байна дундаж гээд. Тэгээд энэ юунд нь ингэж дундаж гэдэг үнэлгээ өгөөд байгааг бас нэг тодорхой болгохгүй бол одоо энэ төслийн хувьд зээлдүүлэгчийг тодорхой болгоогүй байна гэж байгаа юм. Тэгээд энэ чинь зээлдүүлэгч нь тодорхой болоогүй тэгээд улмаар явж байгаад Засгийн газрын өрийн баталгаатайгаар нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар энэ зээлийг авах нөхцөлд хүүгийн түвшин бас нэмэгдэх эрсдэл байна гэж байгаа юм. Энийг та хэд юу гэж дүгнэж байгаа вэ? Тэгээд сүүлд нь болохоор энэ Төсвийн байнгын хороон дээр нэг ажлын хэсэг гаргаж байгаад нийслэл хотын 2 иргэнээс автомашины татвар нэмэх санал дээр үндэслээд нийслэлийн автомашины татварыг нэмсэн асуудал энэ олон нийтийн дунд нэлээн шүүмжлэл дагуулсан учраас Төсвийн байнгын хорооноос ажлын хэсэг гараад дүгнэлтээ боловсруулаад танилцуулах явцдаа Нийслэлийн дарга нарт нэг баахан загнуулсан.

Тэрийг нь хэлсэн чинь та бас намайг одоо нэг попороод томроод байгаарай энэ тэр гээд л янз бүрээр хэлсэн. Тэр нь дүүрч. Тэгээд энэ одоо нөгөө зам ашигласны үгүй автомашины татвар нэмсэнтэй холбоотой Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороон дээрээс.

Х.Ганхуяг: Цогтбаатар гишүүн нэмэлт.

Да.Цогтбаатар: Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороон дээрээс гаргасан тэр нөгөө нэг Засгийн газарт өгсөн нэг дүгнэлт байгаа чиглэл. Тэгээд тэрийг ямархуу шатанд явж байгаа талаар бас мэдээлэл өгөөч? Яг автомашин ашиглаж байгаа хүмүүсийн татвар нэмсэн эсэх асуудал эргэж буусан уу яг тэр өндөр чигээрээ явахаар болсон уу гэдэг дээр бас нэг та тодруулга өгөөч.

Х.Ганхуяг: Нямбаатар дарга хариулах уу? Нямбаатар дарга микрофон өгье.

Х.Нямбаатар: Юу л даа. Автомашины татвартай холбоотой асуудал бол НИТХ-ын эрх хэмжээний асуудал байгаа. Тэгэхээр НИТХ уг асуудлыг шийдэх ёстой. Өнөөдөр маргааш 2 НИТХ хуралдаж байгаа. Энэ дээр хэлэлцэх асуудлын

дараалалд уг асуудал ороогүй байна лээ. Улсын Их Хурал Орон нутгийн татварын дээд доод хувь хэмжээг тогтоох асуудал Улсын Их Хурал орон нутгийн иргэдийн хуралд чиглэл өгөх тийм хууль зүйн зохицуулалт байхгүй гэдэг ийм санал дүгнэлт хамгийн сүүлд гарсан гэж би сонссон. Тухайн үед ажлын хэсгийг Аубакир гишүүн ахалж байсан.

Хоёрдугаарт нь юу гэлээ? Тийм. Энэ бид юун дээр танилцуулгыг хүргүүлэхдээ Засгийн газрын тогтоолд үндэслэж Эрдэнэс Монгол гэдэг тогтоолыг үндэслэсэн. Эрдэнэс Монгол нь энэ.

Х.Ганхуяг: Микрофоноо нэмээд сонгоод өгчих.

2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 257 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Нийслэлийн 1 дүгээр тойрог хурдны замын төсөл арга хэмжээний 15 хувийг төслийг хэрэгжүүлэх хугацаанд үе шаттай гаргаж санхүүжүүлэхийг Эрдэнэс Монголд даалгасан. ЭТТ нь өөрөө Эрдэнэс Монголын бүрэлдэхүүн компани учраас дотооддоо ямар шийдэл гаргасныг бол би компанийн дотоод асуудлыг мэдэхгүй байна. Бид бол Засгийн газрын тогтоолоо л 257 дугаар тогтоолоо л барьж төслийнхөө ТЭЗҮ-ийг боловсруулж явж байгаа.

Х.Ганхуяг: 9 номер.

С.Тулга: Сайн байна уу? Тулгаа Сангийн яам. Энэ нөгөө Засгийн газраас энэ төслийн эрсдэлийн дундаж хэмжээгээр үнэлсэн гэдэг шалтгаан нь бол бид өрийн баталгаа бол ерөнхийдөө 2 юмыг харж байгаа. Нэгд нь төслийг нь харж байгаа. Нөгөө тал нь баталгаа гаргуулагчийг нь харж байгаа. Төслийн хувьд бол 2 эх үүсвэрийг судалж байгаа. Нэг дэх нь Хятадын Эксим банк. Эксим банкны хувьд бол 3 хувийн хүүтэй. 16 жилийн хугацаатай, ийм нөхцөлтэй байгаа.

Хоёр дахь нөхцөл нь бол Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк. Тэр банкны зээлийн нөхцөл бол жилийн 5.58 хувийн хүүтэй 23 жилийн хугацаатай ийм байгаа. Тэгээд энэ Засгийн газрын баталгаа гаргахаар ерөнхийдөө совер буюу Засгийн газарт олгодог зээлийн нөхцөлөөр зээл нь олгогдоод явна. Төслийн эргэж төлөгдөх хугацаа нь 10-аас 12 жилийн хугацаатай байгаа. Тэгээд 2028 оноос шууд орлогоо олоод ашиглалтад ороод явахаар жилийн 380 тэрбум төгрөг ашиг олно.

Х.Ганхуяг: Түрүүн уг нь чуулган дээр хариулаад л байх шиг байсан даа тэ? Төслийн бэлэн байдалтай холбоотойгоор Нямбаатар даргын микрофон өгье.

Х.Нямбаатар: Нийслэлийн төслийн нэгдсэн нэгжээс төслийн тендер зарлах тендерийн баримт бичгийг боловсруулах ажил яг ид дундаа орчихсон явж байгаа. Сая Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 8 дугаар сардаа багтаж олон улсын нээлттэй тендерийг зарлаа гэдэг үүрэг даалгавар өгсөн. Энэний дагуу бид нар энэ тендерийн баримт бичгийг боловсруулах ажил хийгдэж байгаа. Төслийн бэлэн байдалтай холбоотой асуудал дээр 2, 3 зүйл байгаа.

Нэгдүгээрт тээвэр ложистик.

Хоёрдугаарт эрчим хүчний хангамж, 3 дугаарт түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газрыг илрүүлэх.

Дөрөвдүгээрт тухайн төслийн нэгжийн үйл ажиллагаа явуулах барилгын талбайн сонголтыг бий болгох гээд. Бид нар Туулын хурдны зам дээр бол энэ төслийн бэлэн байдлыг бүхэлд нь хангасан. Тойрог хурдны зам дээр бэлтгэл ажил хангагдаад явж байгаа. Дундаж үнэлгээний хувьд бол Сангийн яам бид нарыг хэт өөдрөг олон машин гарна.

Х.Ганхуяг: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Үг байхгүй шүү дээ.

Зарчмын зөрөөтэй санал гараагүй тул тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулах буюу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдээс тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гараагүй тул “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлуулах горимыг дэмжье гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал дэмжигдлээ. 88.2 хувиар.

17 гишүүнээс 15 гишүүн дэмжсэн байна аа.

Ажлын хэсэгт баярлалаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг гишүүн танилцуулъя.

Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

10.50 цаг

Гурав дахь асуудалдаа оръё.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж эхэлье ээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.3.3-д дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн Дэд хорооны бүрэлдэхүүний тогтоол батална гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27.3.3 Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Төсвийн зарлагын хяналтын дэд хороог байгуулахаар заасан. Үүний дагуу Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэнэ ээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.7 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооноос бусад дэд хорооны бүр түүнд зөвхөн харьяалах Байнгын хорооны гишүүд орох бөгөөд Дэд хорооны бүрэлдэхүүн нь тухайн Байнгын хорооны гишүүдийн 2-ны 1-ээс илүүгүй байна гэж заасныг баримтлан Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан Алдраа өөрөө байхгүй байна уу тэ. Чинбатын Номин нарыг нэмж оруулахаар танилцуулж байна аа.

Ингэснээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 12 гишүүнтэй болж байна гэсэн үг ээ. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуулттай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудалтай холбогдуулан гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудалтай холбогдуулан нэг үг хэлэх гишүүн байна уу? Мөнхтулга гишүүнийг тасаллаа. Орсон юм уу? Мөнхтулга гишүүний микрофон өгье.

П.Мөнхтулга: Бүгдээрэнд нь өдрийн мэнд ээ.

Одоо манай Байнгын хороон дээр чинь шинээр нэмэгдээд бүрэлдэхүүн нь тэлээд 29 болж байгаа юм шиг байгаа юм.

Тэгэхээр нөгөө Зарлагын дэд хорооны пропорц нь өөрчлөгдөх үү гэдэг ийм асуултыг Байнгын хорооны даргаас л асуух байлгүй тиймээ. Пропорц нь өөрчлөгдөөд нөгөө сөрөг хүчнээс тэд, олонхоос тэд гэсэн нэг пропорц яваад байдаг шүү дээ хууль дээр. Тэрүүгээрээ бид нар хүн нэмэгдэхлээр дэд хорооны бүрэлдэхүүн бас нэмэгдэж таарах гээд байна.

Тэгэхээр тэр бүрэлдэхүүнийг бас энэ хурал дээрээ шийдээд тэгээд бүрэлдэхүүний даргыг хурлаараа шийдэх АН-ын бүлэг дээр сая яриад энэ удаагийн дэд хорооны даргын нэрийг оруулж ирсэн байгаа байх. Танд хүргэгдсэн байгаа байх.

Х.Ганхуяг: Нэр одоохондоо ирээгүй байна. Даргын асуудал бүүр нэг цагийн хуралдаанаараа шийднэ. Өнөөдөр бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах юун дээрээ л цөмөөрөө санал хураалт явуулна гэсэн үг. Энэ бүрэлдэхүүнтэй холбоотойгоор бүх бүлгүүдээс санал авсан байгаа. Санал авсан байгаа шүү.

Миний дууг жоохон чангалаад өгөөрэй. Бүгдийнх нь дууг бас чангалаад өгөөрэй. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудалтай холбогдуулан үг хэлж, асуулт асууж дууслаа. Гишүүд санал хураалтад бэлдье.

Одоогоор тоо нэмэхээр бүлгүүдээс ямар нэгэн санал ирээгүй гэсэн үг. Тийм бүлгээс саналыг чинь аваад л оруулж танилцуулж байгаа гэсэн үг. Одоогоор тоо нэмэхээр бүлгүүдээс ямар нэгэн санал ирээгүй гэсэн үг. Тийм бүлгээс саналыг чинь аваад л оруулж танилцуулж байгаа гэсэн үг. Тэрэн дээр нэг цагийн үгээ цөмөөр дахин ярилцъя аа. тэгээд чуулганаар цөмөөрөө бүрэлдэхүүнээ батлуулна гэсэн үг.

Тэгээд 1 цагийн хуралдаанаар даргаа тодруулна гэсэн үг.

Алдаржавхлан гишүүн, Номин гишүүн. Нийт гишүүдийг танилцуулъя. Нэгд Жуковын Алдаржавхлан, Далайн Батбаяр, Ринчендоржийн Батболд, Жигжидийн Батжаргал, Пүрэвжавын Ганзориг, Батжаргал Жаргалын Заяабал, Загджавын Мэндсайхан, Чинбатын Номин, Даваахүүгийн Пүрэвдаваа, Банзрагчийн Түвшин, Даваагийн Цогтбаатар Булгантуяа.

Санал хураалтад бэлдье.

Гишүүд хуруугаа уншуулаарай. Болсон уу? Булгаа хуруугаа, ороогүй л гэж харагдаад байх юм.

Монгол Улсын Их Хурлын Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан, Чинбатын Номин нарыг нэмж оруулахыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя аа.

88.9 хувиар санал дэмжигдсэн байна.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Чинбатын Номин гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

11.01 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА